



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны "Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай" 318 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 нэрийн, нийт 263,366,065.65 (хоёр зуун жаран гурван сая гурван зуун жаран зургаан мянга жаран таван төгрөг жаран таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийн захирал, дарга, "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Дагдан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004824  
9-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт

"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанид **балансаас балансад**  
**шилжүүлэх хөрөнгийн жагсаалт**

Д/д	Байгууллагын нэр	Тоноглолын марк	Тоноглолын нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	
1	"Үндэсний дата төв" УТҮГ	10 кВ XLPE 3*120	Үйлчилгээний барилгын кабель	2020	М	1855	142,464,000.00	
2		ХТП-342-д тавигдсан ачаалал таслагч /КСО-386/						
3	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хумуунлэгийн сургууль	ХТП-713 дэд өртөөний 0.4 кВ-ын тоноглол, 0.4 кВ-ын кабель	Үйлчилгээний барилгын гадна цахилгаан	2021	КОМ	1	45,739,398.85	
4	"Налайхын дулааны станц" ТӨХК	ХТП-7100-ын 10 кВ-ын тоноглолт	ХТП-ын 10 кВ-ын тоноглол	2018	КОМ	1	38,556,000.00	
5	Цөмийн энергийн комиссын ажлын алба	35/0.4 кВ-ын дэд станц	35/0.4 кВ-ын дэд станц	2010	КОМ	1	606,666.80	
							<b>263,366,065.65</b>	
<b>НИЙТ ДҮН</b>								<b>(хоёр зуун жаран гурван сая гурван зуун жаран зургаан мянга жаран таван төгрөг жаран таван мөнгө)</b>